

**“ЭСВАТИНИЙН ХААНТ УЛСТАЙ ДИПЛОМАТ ХАРИЛЦАА ТОГТООХ ТУХАЙ”
УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙГ ХЭЛЭЛЦСЭН ТАЛААРХ АЮУЛГҮЙ
БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2025 оны 07 дугаар
сарын 01-ний өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч: Улсын Их Хурлын гишүүн Г.Хосбаяр

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Эсватинийн Хаант Улстай дипломат харилцаа тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 80 дугаар зүйлд заасны дагуу Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 2025 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Эсватинийн Хаант Улстай дипломат харилцаа тогтоосноор хоёр талын харилцааг хөгжүүлж, хоёр талын болон олон талт тогтолцооны хүрээнд нийтлэг эрх ашгийн төлөө харилцан дэмжлэг үзүүлж, Нэгдсэн Үндэстний Байгууллага, түүний төрөлжсөн байгууллагууд, Дэлхийн худалдааны байгууллага зэрэг олон талт тогтолцоо, механизмын хүрээнд хамтран ажиллах нөхцөл бүрдэнэ.

Байнгын хорооны хуралдаанаар дээрх асуудлыг хэлэлцэх үед гишүүд асуулт асууж, үг хэлээгүй болно.

“Эсватинийн Хаант Улстай дипломат харилцаа тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Эсватинийн Хаант Улстай дипломат харилцаа тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД
БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА**



Г.ТЭМҮҮЛЭН